

## **МОНГОЛ УЛСЫН СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ЭЧНЭЭ, ЗАЙН ХӨТӨЛБӨРТ 2016 ОНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

### **1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Монгол Улсын Соёл Урлагийн Их Сургуулийн бакалаврын эчнээ, зайн хөтөлбөрт 2016 онд оюутан элсүүлэхэд БШУ-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, 2014 оны А/78 дугаар тушаалаар батлагдсан дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл (хөтөлбөр), индекс болон энэхүү журмыг баримтална.
- 1.2. СУИС-д элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.3. СУИС-ийн бакалаврын эчнээ, зайн хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, зохих болзол хангасан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс” гэнэ.
- 1.4. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
- 1.5. Бакалаврын эчнээ, зайн хөтөлбөрт суралцагч элсүүлэх ажлыг СУИС-ийн захирлын тушаалаар томилогдсон элсэлтийн комисс зохион байгуулна.

### **2. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 2.1. Эчнээ, зайн сургалтанд дараах хүмүүсийг элсүүлнэ. Үүнд:
  - Бүрэн дунд боловсролтой, тухайн суралцах хөтөлбөрийн чиглэлээр мэргэжлийн урлагийн байгууллагад 3-аас дээш жил ажиллаж байгаа;
  - Суралцах хөтөлбөрийн чиглэлийн, эсвэл өөр мэргэжлээр дипломын зэрэгтэй;
  - Өөр мэргэжлийн бакалавр зэрэгтэй;

### **3. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ**

- 3.1. Эчнээ, зайн сургалтанд элсэгчдэд тавигдах шаардлагыг хангасан хүмүүсийг 2016 оны 9 дүгээр сарын 12-ноос 30-ны өдрүүдэд цахимаар бүртгэх бөгөөд дараах баримт бичгүүдийн нотариатаар баталгаажуулсан хуулбарын зургийн файлыг бүртгэлийн маягт ([www.msuc.edu.mn](http://www.msuc.edu.mn) хаягаар орж бөглөнө)-ын хамт [info@msuc.edu.mn](mailto:info@msuc.edu.mn) хаягаар илгээж бүртгүүлнэ. Үүнд:
  - Боловсролын зэргийн диплом, гэрчилгээ;
  - Ажиллаж буй байгууллагын тодорхойлолт, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;
  - Иргэний цахим үнэмлэхний хуулбар;
  - Бүртгэлийн хураамж төлсөн баримт (Төрийн банк дахь СУИС-ийн 102900116087 тоот дансанд тушаах);
- 3.2. Урлагийн авъяас шаардахгүйгээр элсүүлэх хөтөлбөрийн бүртгэлийн хураамж 8,000 төгрөг, ур чадварын шалгалт авч элсүүлэх хөтөлбөрийн бүртгэлийн хураамж 15,000 төгрөг байна.
- 3.3. Бүртгүүлэгч нь нэг түүнээс дээш хөтөлбөрт бүртгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд хөтөлбөр тус бүрээр бүртгэлийн хураамж төлнө.
- 3.4. Суралцагч элсүүлэх хөтөлбөр, ур чадварын шалгалтын агуулгыг хавсралтад заасан ба бүртгэл явагдах хугацаанд СУИС-ийн бүтцийн сургуулиуд нь хэрэгжүүлж буй бакалаврын хөтөлбөрүүдээ танилцуулах, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг хүлээнэ.

### **4. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ БА МЭДЭГДЭХ**

- 4.1. Ур чадвар шаардах хөтөлбөрийн элсэлтийн шалгалтыг 2016 оны 10 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж, дүнг мэдээлнэ.

- 4.2. Ур чадварын шалгалтын дээд оноо 800 байна.
- 4.3. СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль, Бүжгийн урлагийн сургууль, Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж, Улаанбаатар хотын Хөгжим бүжгийн коллежийн төгсөгчийг ур чадварын шалгалт авахгүйгээр тухайн хөтөлбөрт элсүүлж болно.

#### **5. ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ**

- 5.1. Ур чадварын шалгалтын дүн, тухайн хөтөлбөрийн анги дүүргэлтийг харгалзан элсэгчдэд СУИС-д сурах эрх олгоно.

#### **6. ЭЛСЭГЧДИЙН БҮРТГЭЛ**

- 6.1. СУИС-д сурах эрх авсан элсэгч нь 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр бүтцийн сургуулийн сургалтын албанд бүртгүүлэхдээ бүрдүүлсэн баримт бичгүүдийг эх хувиар нь авч ирэн суралцах гэрээ байгуулах ба шаардлагатай бол кредит дүйцүүлэлт хийж, кредит шууд тооцох шалгалтанд бүртгүүлнэ.
- 6.2. 2016-2017 оны хичээлийн жилийн эчнээ сургалт 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр, зайн сургалт 2016 оны 10-р сарын 17-ны өдөр эхэлнэ.

#### **7. ЭЛСЭЛТИЙН КОМИССЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 7.1. Элсэлтийн комисс нь бүртгүүлэгчдийн мэдлэг, авъяас, чадварыг үнэн зөв, шударга, бодитой үнэлэн сонгон шалгаруулах үүрэгтэй.
- 7.2. Оюутан элсүүлэхтэй холбоотой аливаа маргааныг “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, БСШУСЯ-ны Сайдын баталсан “Оюутан элсүүлэх журам”, бусад холбогдох хууль, дүрэм журам болон энэхүү журмыг баримтлан Элсэлтийн комисс ажлын 7 хоногт багтаан эцэслэн шийдвэрлэнэ.

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 26

Харилцах утас: 11-326129 (Сургалтын бодлого зохицуулалтын газар)

СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ

**СУИС-ИЙН БАКАЛАВРЫН ЭЧНЭЭ СУРГАЛТАНД  
ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД**

№	Хөтөлбөр
1.	021104. “Радио, дэлгэцийн техник технологи”
2.	031401. “Соёл судлал” / <i>нүүдлийн соёл судлал, өрнийн соёл судлал, соёлын өв, музей судлал/</i>
3.	032201. “Номын сан судлал” (алсын зайн сургалттай)
4.	041302. “Менежмент” / <i>соёл, урлаг/</i> , (алсын зайн сургалттай)
5.	041401. “Маркетинг” / <i>соёл, урлаг/</i>
6.	101501. “Аялал жуулчлал” / <i>соёлын аялал жуулчлал, соёл чөлөөт цагийн үйлчилгээ/</i>
7.	011404. “Багш, урлагийн боловсрол” / <i>хөгжмийн, бүжгийн/</i>
8.	021101. “Зураг авалт”
9.	021102. “Дуу чимээний технологи”
10.	021201. “Хувцасны дизайн”
11.	021202. “График дизайн” / <i>компьютер график, мультимедиа, хэвлэлийн дизайн/</i>
12.	021301. “Уран зураг” / <i>уран зураг, монгол зураг, монументаль уран зураг, тайз дэлгэцийн/</i>
13.	021302. “Уран баримал” / <i>уран баримал, керамик урлаг, арьсан урлаг, чимэглэх урлаг, уран дархан, уран сийлбэр/</i>
14.	021303. “Зураасан зураг”
15.	021304. “Түүх соёлын дурсгалт зүйлийн сэргээн засварлалт”
16.	021501. “Хөгжмийн урлаг” / <i>зохиомж, найруулга, судлал, удирдах-найрал дуу, найрал хөгжим/</i>
17.	021502. “Хөгжимдөх урлаг” / <i>сонгодог ба үндэсний хөгжим, концертмейстр, орчин цагийн хөгжим/</i>
18.	021503. “Дуулах урлаг” / <i>дуурийн, уртын, богинын, орчин цагийн/</i>
19.	021504. “Үндэсний язгуур урлаг” / <i>хөөмэй, тууль/</i>
20.	021505. “Жүжиглэх урлаг”
21.	021516. “Найруулах урлаг” / <i>кино, радио, телевиз, жүжиг/</i>
22.	021507. “Бүжгийн урлаг” / <i>бүжгийн найруулга, жүжиглэх урлаг/</i>
23.	021801 “Урлаг судлал” / <i>театр, кино, дүрслэх урлаг/</i>
24.	023203 “Утга зохиол судлал” / <i>кино, жүжгийн зохиол/</i>
25.	032101 “Сэтгүүл зүй”

Тайлбар:

- Ур чадварын шалгалт өгч элсэх хөтөлбөрүүд (Шалгалтын хэлбэр агуулгыг II-р хавсралтаас үз.)

## УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ ӨГЧ ЭЛСЭХ ХӨТӨЛБӨРҮҮД

Хөтөлбөр	Ур чадварын шалгалт (800 оноо)	
	Ерөнхий чадвар	Онцлог чадвар
011404. “Багш, урлагийн боловсрол” <i>/хөгжмийн, бүжгийн/</i>	<u>Хөгжмийн</u> а) Хөгжимдөх чадвар (төгөлдөр хуураар 2 зохиол) б) Хэмнэл в) Сонголт, ой тогтоолт	а) Сонгосон хөгжмийн зэмсгээр 2 зохиол хөгжимдөх б) Урлагийн тухай ярилцлага в) Биеийн хөгжил г) Дуулах чадвар
	<u>Бүжгийн</u> а) Бие бялдарын хөгжил, уян хатан чанар б) Сонголт, ой тогтоолт, хөгжмийн мэдрэмж в) Бүжиглэх авьяас чадвар г) Үсрэлт, хөдөлгөөний эвсэл	
021101. “Зураг авалт”	а) Ярилцлага б) Уран чадвар	
021102. “Дуу чимээний технологи”	а) Сонголт, ритм, ой тогтоолт б) Ярилцлага	
021201. “Хувцасны дизайн”	а) Зохиомж б) Хар зураг в) Уран зураг	
021202. “График дизайн” <i>/компьютер график, мультимедиа, хэвлэлийн дизайн/</i>		
021301. “Уран зураг” <i>/уран зураг, монгол зураг, монументаль уран зураг, тайз дэлгэцийн/</i>		
021302. “Уран баримал” <i>/уран баримал, керамик урлаг, арьсан урлаг, чимэглэх урлаг, уран дархан, уран сийлбэр/</i>		
021303. “Зураасан зураг”		
021304. “Түүх соёлын дурсгалт зүйлийн сэргээн засварлалт”		
021501. “Хөгжмийн урлаг” <i>/зохиомж, найруулга, судлал, удирдах-найрал дуу, найрал хөгжим/</i>	а) Соноршуулга: 2-3 хоолойн диктант б) Хөгжмийн суурь мэдлэг (бодлого бодох, онолын дасгал хийх) в) Төгөлдөр хуураар хөгжимдөх ур чадвар г) Ярилцлага	а) Өөрийн зохиосон хөгжмийн зохиолыг хөгжимдөх, ноотны программын мэдлэг б) Найрал хөгжим удирдах- 2 бүтээл в) Найрал дуу удирдах-2 бүтээл, дуулах чадвар г) Урлагийн тухай эссэ бичих (250-300 үгтэй)
021502. “Хөгжимдөх урлаг” <i>/сонгодог ба үндэсний хөгжим, концертмейстр, орчин цагийн хөгжим/</i>	а) Хөгжимдөх чадвар (төгөлдөр хуураар 2 зохиол) б) Хэмнэл в) Сонголт, ой тогтоолт	а) Сонгосон хөгжмийн зэмсгээр 2 зохиол хөгжимдөх б) Урлагийн тухай ярилцлага в) Биеийн хөгжил г) Дуулах чадвар
021503. “Дуулах урлаг” <i>/дуурийн, уртын, богинын, орчин цагийн/</i>	а) Дуулах чадвар (2-3 дуу бэлтгэх) б) Хэмнэл, в) сонголт, ой тогтоолт г) Хөгжимдөх чадвар	а) Биеийн хөгжил (Хоолойн цараа, амны хөндийн эрүүл ахуй) б) Хөдөлгөөний эвсэл,бүжиг
021504. “Үндэсний язгуур урлаг” <i>/хөөмэй, тууль/</i>		а) Түргэн хэллэг б) Амьсгалын багтаамжийн дасгал
021505. “Жүжиглэх урлаг”	а) Өөрийн судалбар б) Хөдөлгөөний эвсэл, бүжиг в) Дуулах чадвар г) Сонголт, ритм д) Уран уншлага	а) Ёгт үлгэр ярих б) Монолог в) Өгөгдсөн судалбар г) Ярилцлага

021516. “Найруулах урлаг” <i>/жүжиг/</i>	а) Өгөгдсөн судалбар б) Хөдөлгөөний эвсэл, бүжиг в) Дуулах чадвар г) Сонгол, ритм д) Уран уншлага	а) Өөрийн судалбар б) Эссэ бичих в) Ярилцлага
021516. “Найруулах урлаг” <i>/кино, радио, телевиз/</i>	а) Ярилцлага б) Эссэ бичих в) Оюуны чадамж IQ	
021507. “Бүжгийн урлаг” <i>/бүжгийн найруулга, бүжиглэх урлаг/</i>	а) Бие бялдрын хөгжил, уян хатан чанар б) Сонгол, ой тогтоолт, хөгжмийн мэдрэмж в) Бүжиглэх авьяас чадвар г) Үсрэлт, хөдөлгөөний эвсэл	
021801 “Урлаг судлал” <i>(театр, кино, дүрслэх урлаг)</i>	а) Эссэ бичих	
023203 “Утга зохиол судлал” <i>(кино, жүжгийн зохиол)</i>	б) Ярилцлага	
032101 “Сэтгүүл зүй”	а) Ярилцлага б) Эссэ бичих в) Оюуны чадамж IQ	